



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/504

Ховд

П.Алтанлхагвад сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаст Алтай цогцолбор сургуулийн нэр бүхий багш, ажилтнуудаас ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтээр тус сургуулийн захирал П.Алтанлхагва нь нэгдсэн удирдлагаар хамт олныг хангаагүй, багшийн сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжид заасны дагуу явуулаагүй, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тавьдаггүй, санхүүгийн сахилга бат сул зэрэг зөрчлүүд илэрсэн тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Байгууллагын багш, ажилчдыг нэгдсэн удирдлагаар хангаж, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлж, байгууллага, хамт олны эв нэгдлийг хангаж ажиллахыг П.Алтанлхагвад үүрэг болгосугай.

3. Захирамжийг холбогдох албан тушаалтанд хүргэж, хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ

